



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2012 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 5/38

Улаанбаатар хот

Ч.Цогийг ажилд томилох тухай

Монгол Улсын “Төрийн албаны тухай хууль” - ийн 17 дугаар зүйлийн 17.4, 18 зүйлийн 18.1 дэхь хэсэг, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль” - ийн 17 зүйлийн 17.1.12 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дэхь хэсэг, “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журам”-ын 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ


1. Чулуунтөмөр овогтой Цогийг “Хүний нөөц, хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн” албан тушаалд 2012 оны 11 дүгээр сарын 29-ны өдрөөс эхлэн нэг жилийн туршилтын хугацаагаар томилон ажиллуулсугай.

2. Ч.Цогийн сарын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 78 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээний дагуу /ТЗ-5-1/ 443.433 / дөрвөн зуун дөчин гурван мянга дөрвөн зуун гучин гурван/ төгрөгөөр цалинжуулж, холбогдох журмын дагуу унаа, хоолны хөнгөлөлтийг олгохыг нягтлан бодогч / П.Ариунаа /-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон мэргэжилтнүүдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн нууцлал хангах үйл ажиллагаа болон ажил хавсран гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хууль, тогтоомжид нийцүүлэн сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож нэмэгдэл олгохыг нягтлан бодогч / П.Ариунаа /-д зөвшөөрсүгэй.

4. Ч.Цогийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэн ажиллахыг ахлах мэргэжилтэн / Ц.Цолмон / - д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН